



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ СУМЫН ХАМТАРСАН БАГ

Шарын гол сумын засаг дарга Д.Амарсанаа



ШАРЫН ГОЛ СУМЫН ХАМТАРСАН БАГ



Сумын хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/328 дугаар тушаалын дагуу сумын Засаг даргын захирамжаар Хайрхан /А/55/, Дархан /А/56/, Санжинт /А/57/ баг тус бүр дээр 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан ажиллаж байна.





ШАРЫН ГОЛ СУМЫН ХАМТАРСАН БАГ 2019 ОНД

2019 онд хамтарсан баг тус бүр 6 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан 9 дүгээр сарын байдлаар төлөвлөөний хэрэгжилт 83,3%-тай байна.

Аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх зорилгоор эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа иргэдийн судалгааг гарган, судалгаанд тулгуурлан хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Хайрхан багийн 14 өрхийн 43 хүүхэд, Дархан багийн 12 өрхийн 26 хүүхэд, Санжинт багийн 15 өрхийн 36 хүүхэд нийт 41 өрхийн 105 хүүхдийн судалгааг шинэчлэн гаргаж хамтарсан багийн хяналтанд аван ажиллаж байна.



ШАРЫН ГОЛ СУМЫН ХАМТАРСАН БАГ 2019 ОНД

2019 оны 9 дүгээр сарын байдлаар хамтарсан багийн товлосон хурал 2 удаа, шуурхай хурал 7 удаа хуралдсан байна. Нийт 5 кейс, гэр бүлийн хүчирхийллийн-3 тохиолдол бүртгэгдсэнээс одоогийн байдлаар хаагдсан кейс байхгүй, кейс тус бүр дээр хувийн хэрэг үүсгэн шийдвэрлэлтийн шатанд дараах үйлчилгээнүүдэд холбон зуучлан ажиллаж байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ – 3
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар – 2
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллага – 2
- Түр хамгаалах байр – 3
- Хууль эрх зүйн зөвлөгөө – 10
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ - 5



СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА НӨЛӨӨЛЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

2019 оны 4 дүгээр сард "ГЭР БҮЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ ЭРХ ТЭГШ ХАРИЛЦАА" сэдэвт уулзалт зөвлөгөөнийг 12 жилийн 2 болон 6 дугаар сургуулийн дунд, ахлах ангийн 80 сурагчид эцэг эхийн хамт нийт 240 хүний бүрэлдэхүүнтэй оролцож "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга", "Гэр бүлийн тогтвортой байдал, харилцаа хандлага" сэдвээр сургалт нөлөөллийн ажлын зохион байгуулсан.





СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА НӨЛӨӨЛЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн их эмч, нөхөн үржихүйн бага эмч, Шарын гол сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэсээс Ерөнхий боловсролын 12 жилийн 2 болон 6 дугаар сургуулийн 161 охидод “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх” талаарх сургалтыг зохион байгуулж, үзлэг хийн ЕБС-ийн сурагчдад хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээллийг өгсөн.






108 УТАСНЫ ДУУДЛАГА

Шарын гол суманд хандсан дуудлага мэдээлэл өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна

Дуудлага





2018 онд хамтарсан багийн анхан шатны нэгжээс хүлээн авсан мэдээлэл буй 3 кейс дээр ажилласан





ХАМТАРСАН БАГААР АЖИЛЛАСАН ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ ЖИШЭЭ, ГАРСАН ҮР ДҮН, ЭЕРЭГ СӨРӨГ ҮЗҮҮЛЭЛТ

Шалтгаан:

Дархан багийн иргэн “З” нь архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас хүүхдүүдээ үл хайхрах хүчирхийлэлд өртүүлсэн, энэ байдал нь даамжирсаар 14 настай охин “Н” нь 14 хоног шалтгаангүйгээр хичээл тасалсан, гэрээсээ дайжсан гэх шалтгаанаар 12 жилийн 6 дугаар сургуулийн нийгмийн ажилтны мэдээллэсний дагуу хамтарсан багаар хуралдан төлөвлөгөө боловсруулан ажилласан

Үр дүн:

- “Түр хамгаалах байр”-д хүргэж 20 хоног байлгаж, хүүхдүүдэд эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө, сурч боловсрох нөхцлөөр хангасан
- Ээжийг сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэн хордлого тайлах, сэтгэл засалын эмчилгээ хийгдсэний үр дүнд эхний үед өөртөө итгэх итгэл нэмэгдэж өөрийн хичээл зүтгэлээр архины хамаарлаас гарч, Шарын гол сумын АА-бүлгийн идэвхитэй гишүүн болсон. Гэвч зуучилж өгсөн ажлаас татгалзаж яваандаа аажим аажмаар архины хамааралтай болж эхэлсэн.
- 3 хүүхдийг нь бичиг баримттай болгосон.

ХАМТАРСАН БАГААР АЖИЛЛАСАН ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ ЖИШЭЭ, ГАРСАН ҮР ДҮН, ЭЕРЭГ СӨРӨГ ҮЗҮҮЛЭЛТ

- Засаг даргын А/139 дугаар захирамж гарч, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг гаргуулсан.
 - Эрүүл аюулгүй орчинд амьдруулах зорилгоор амьдарч байсан хуучин байшинд нь урсгал засвар тохижилт хийж, жилийн хэрэгцээний нүүрс, түлээний модыг бэлдэж, гэр бүлийн бүх гишүүдийг шаардлагатай өвлийн дулаан хувцасаар хангах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.
 - Энэхүү кейс дээр нийт 3.018.200 төгрөгийг зарцуулсан.
 - Хүүхдүүд дассан орчиндоо амьдарч, зан төлөвийн хувьд эерэг өөрчлөлтүүд гарч анги хамт олон, найз нөхдийнхөө дунд үнэлэглэх болсон.
 - Том охины хувьд зан төлөвийн хувьд төлөвшиж, өөрийн дуртай дуу хөгжимдөө хөтлөгдөн идэвхтэй суралцаж сурлагын үнэлгээний хувьд ахисан үзүүлэлттэй байна.
-



Анхаарал хандуулсанд баярлалаа

Их мэдлэгтэй хүмүүжилгүй хүн
төлөвшүүлснээс магадгүй нимгэн
мэдлэгтэй боловч хүн шиг хүн
төлөвшүүлэх нь эх оронд
хэрэгтэй.